

Сууц өмчлөгчдийн холбоог шинээр байгуулж, Хан -Уул дүүрэгт бүртгүүлэхэд
шаардлагатай бүрдүүлэх материалын жагсаалт

1. Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт хандсан албан хүсэлт
2. Оршин суугчдын хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл, бүх гишүүдийн хурлын тогтоол/ сууц өмчлөгчдийн холбоо байгуулсан, сууц өмчлөгчдийн нэр өгсөн, Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, тэдгээрийн овог нэр, гэрийн хаягийн хамт, сууц өмчлөгчдийн холбооны дүрэм баталсан зэрэг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх асуудлыг бүрэн тусгасан байна/ тогтоолд хурлын тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажуулна. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийн тоо сондгой байхыг анхаарна уу.
3. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл тус тусдаа даргаа сонгосон тогтоол /Удирдах зөвлөл,Хяналтын зөвлөлийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
4. Удирдах зөвлөлийн гүйцэтгэх захирлыг томилсон тогтоол /Удирдах зөвлөлийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна/.
5. Оршин суугчдын хурлыг ирцийг тодруулж оролцогсдын гарын үсэг, харилцах утасны дугаар, хурал хийж байх үеийг баримтжуулсан фото зураг зэрэг нотлох баримт
6. Сууц өмчлөгчдийн холбооны дүрэм
7. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийн товч анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, өмчлөгчийн гэрчилгээний хуулбар
8. Барилгыг ашиглалтад хүлээн авсан улсын комиссын актын хуулбар

Жич: Бүх материалыг 2 хувь үйлдэж, 1 хувийг сууц өмчлөгчдийн холбоо өөртөө баримт болгон үлдээнэ.

Сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн О.Анхтуяа
Утас -77771965, 94014843

Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр, 4 давхар 402
ТООТ